**МОНГОЛ УЛСЫН**
**БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ**
**САЙДЫН ТУШААЛ**

2014 оны 12 сарын 02 өдөр Дугаар А/466 Улаанбаатар хот

Зарим багш, судлаачдыг
Япон Улсад суралцуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2014 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн А/308 дугаар тушаалаар батлагдсан "Япон Улсад инженер, технологийн чиглэлээр коосэн, хамтарсан бакалавр, магистр, доктор, зэргийн бус сургалтын хөтөлбөрт оюутан суралцуулах журам"-ын 2.7, 2.9 дэх заалт, Инженер, технологийн дээд боловсрол төслийн Удирдах хорооны 2014 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Инженер, технологийн дээд боловсрол төслийн шугамаар 2014-2015 оны хичээлийн жилээс Япон Улсын их сургуулиудын магистр, доктор, зэргийн бус сургалтын хөтөлбөрт суралцуулах багш, судлаачдын нэрсийг хавсралт ёсоор баталсугай .

2.Япон Улсад суралцах багш, судлаачидтай журмын дагуу сургалтын зээлийн гэрээ байгуулж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Сургалтын төрийн сан /Б.Мөнхцэцэг/, Монгол улсын их сургууль /А.Галтбаяр/, Шинжлэх ухаан, технологийн их сургууль /Б.Очирбат/ нарт тус тус даалгасугай.

3.Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж, удирдлагаар хангаж ажиллахыг Стратегийн бодлого, төлөвлөлтийн газар /Б.Насанбаяр/, Дээд боловсролын хэлтэс /П.Эрхэмбулган/, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс /Ц.Баярхүү/-т тус тус үүрэг болгосугай.

Л.ГАНТӨМӨР

Боловсрол, шинжлэх ухааны сайдын
2014 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн
А/466 дугаар тушаалын хавсралт

**ЯПОН УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН МАГИСТР, ДОКТОР, ЗЭРГИЙН БУС СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРТ 2014-2015 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛЭЭС СУРАЛЦАХ БАГШ, СУДЛААЧДЫН НЭРС**

| д/д | Эцэг, (эх)-ийн нэр, нэр | Ажиллаж буй сургууль | Японд Улсад суралцах сургууль | Суралцах хугацаа | Судалгааны чиглэл | Хамрагдах хөтөлбөр |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Даваажав Нарантогтох | ШУТИС-ийн багш | Киотогийн технологийн их сургууль | 2015 оны 1 дүгээр сараас 4 дүгээр сар хүртэл /3 сарын хугацаанд/ | Дэвшилтэт материалын судалгаа, нэхмэл ба ноолууран түүхий эдийн био-инженерчлэлийн судалгаа | Зэргийн бус |
| 2 | Орхон Банзрагчгарав | МУИС-ийн эрдэм шинжилгээний ажилтан | Тоохокугийн эм зүйн их сургууль | 2015 оны 1 дүгээр сараас 4 дүгээр сар хүртэл / 3 сарын хугацаанд | Зелесовын зэдгэлжийн фотохимийн болон биологийн судалгаа | Зэргийн бус |
| 3 | Мөнхбат Долгормаа | МУИС-ийн эрдэм шинжилгээний ажилтан | Мияазакигийн их сургууль | 2015 оны 1 дүгээр сараас 4 дүгээр сар хүртэл /3 сарын хугацаанд/ | Дэвшилтэт материалын судалгаа, хүрээлэн буй орчны инженерчлэл | Зэргийн бус |
| 4 | Нямсүрэн Гомбосүрэн | ШУТИС-ийн ахлах багш | Рицүмэйкан их сургууль | 2015 оны 1 дүгээр сараас 8 дугаар сар хүртэл /8 сарын хугацаанд/ | Бензинт хөдөлгүүрийн сольдог урьдавч шатах хорго | Зэргийн бус |
| 5 | Дамдинсүрэн Нарантуяа | МУИС-ийн багш | Эхимэгийн их сургууль | 2015 оны 4 дүгээр сараас 5 дугаар сар хүртэл /1 сарын хугацаанд/ | Микробиологи | Зэргийн бус |

44

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 6 | Отгонбаатар Энхцолмон | ШУТИС-ийн багш | Китакюшюгийн их сургууль | 2015 оны 4 дүгээр сараас 2016 оны 4 дүгээр сар хүртэл /1 жилийн хугацаанд/ | Дулаан идэвхжүүлэх хагас дамжуулагчаар дэгдэмхий органик нэгдэл болон нарийн ширхэглэлт тоосонцорыг арилгах | Доктор |
| 7 | Пүрэвсүрэн Нэмэхбаяр | ШУТИС- ийн эрдэм шинжилгээний ажилтан | Нагоягийн их сургууль | 2015 оны 4 дүгээр сараас 2017 оны 4 дүгээр сар хүртэл /2 жилийн хугацаанд/ | Магмын чулуулгийн геохими | Магистр |

-----oOo-----

45